

**ЯПОН УЛСЫН НАГОЯ ХОТОД БОЛСОН ОУ-ЫН ХУРАЛД
ОРОЛЦСОН АЛБАН АЯЛАЛЫН ТАЛААРХ
ИЛТГЭХ ХУУДАС**

Улаанбаатар хот

2014.09.30

Япон улсын Нагоя хотод 2014 оны 9 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд зохиогдсон Хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх Олон улсын нийгэмлэгийн ХХ хуралд тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Батсүх, Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтсийн дарга С.Байгалмаа, мэргэжилтэн Н.Хөхөө нар, 7 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн дарга, ахлах мэргэжилтний хамт амжилттай оролцож ирлээ.

Оролцогсод, бэлэг тэмдэг, арга хэмжээ

- ОУ-ын хэмжээнд 40 гаруй орны 2300 гаруй хүн оролцсон.
- Бэлэг тэмдэг нь улбар шар өнгийн тууз байсан
- Хурлын хугацаанд шилжиж буй орнуудын чуулган, мастерийн сургалт, нээлт, нэгдсэн болон зэрэгцээ хуралдаанууд, соёлын үдэшлэг зэрэг арга хэмжээ тус тус зохион байгуулагдсан.

Шилжиж буй орнуудын чуулган, мастерийн сургалт

- “Соёл ба хүчирхийлэл”
- “Бие махбодын шийтгэлийг төгсгөл болгох нь– Азын санаачлага дэлхийд”
- “Хүүхдийн гэр бүлийн хүчирхийлэлд өртөлт – хүүхдийн хүчирхийллийн хэлбэр”
- “Эхнээс нь дуустал нь зөв ажиллах нь: Ойлголцол, хөндлөнгийн оролцоо болон хохирогчийг эрүүлжүүлэх нь” сэдвээр тус тус хэлэлцсэн.

Хурлын албан ёсны нээлт /2014.09.14-ний өдрийн 16.00 цаг/

- Зохион байгуулагчид нээж үг хэлсэн
- Японы эзэн хааны охин, эрхэмсэг дээд гүнж Акишино хүрэлцэн ирж, илтгэл тавьсан.
- Зочид үг хэлсэн:
 - Yasuhisa Shiozaki-Эрүүл мэнд, хөдөлмөр болон халамжийн яамны сайд
 - Айчи мужийн Засаг дарга болон Нагоя хотын дарга нар
- ХХУСОУН-ийн шагнал гардуулах ёслол болсон.

2 жил тутамд хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэхэд бодитой хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг 3 төрлийн шагналд шалгаруулан шагнадаг. Энэ 2014 оны:

 - “Нэрд гарсан үйлчилгээ” гэдэг шагналыг Францын омбудсман асан Gaby Taub гэдэг эмэгтэй,
 - Хамтарсан багийн шагналыг Беларусын PONIMANIE баг, Саудын арабын ЭМ-ийн Яамны Хүүхэд хамгааллын төв, (орон нутагтаа хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах, ХЭХ-ийг урьдчилан сэргийлэхэд бодит ахиц гаргасан багт олгодог)
 - Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг Aron Bentovin, India нар тус тус шалгаран шагнагдсан.

Нэгдсэн болон зэрэгцээ хуралдаанууд 9 дүгээр сарын 15-17-ны өдөр

- 5 удаагийн нэгдсэн хуралдаан
- 245 бага хурал, илтгэл, хэлэлцүүлгүүд зэрэгцэн явж
- 102 зурагт хуудсан танилцуулга тус тус хийгдсэн.
- А.Батхишиг ирж докторын ажлынхаа танилцуулгыг хийсэн.

Багийн оролцоо

- Шилжиж буй орнуудын хэлэлцүүлэг, нэгдсэн хуралдаанд бүрэн оролцож,
- 20 гаруй зэрэгцээ хуралдаануудад сууж мэдээлэл авч,
- Зурагт хуудсан танилцуулгыг үзэж сонирхсон.

Соёлын үдэшлэгт оролцож ISPCAN , CHI, JaSPCAN-ий ерөнхийлөгч нартай уулзаж ярилцан, бэлэг дурсгалын зүйл гардуулсан.

2014.09.17

- ISPCAN-ий Ерөнхийлөгч Jenny Gray-тэй уулзаж ярилцан:
 - Чадавхжуулах сургалтыг ирэх жил хийх
 - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаандаа зөвлөгөө авах
 - Хүүхэд хамгааллын шинэ хуулийн үзэл баримтлалд зөвлөгөө авахаар тохиролцсон.
- CHI-ийн Гүйцэтгэх захирал Nenita La Rose-тай уулзаж:
 - манай утасны талаар болон
 - 2 хүнээ Лондонд болох хуралд оролцуулах талаар ярьсан.





Хурлын ач холбогдол:

- Нэгдсэн хуралдаан болон салбар хуралдаануудаар улс орнуудын хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч буй арга хэмжээтэй танилцсан.
- Шинэлэг санаа, сайн туршлагаудыг судлах, суралцах боломж бүрдсэн.
- Олон улсын түвшинд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг үзүүлж буй үйлчилгээ, урьдчилсан сэргийлэлт, судалгаа шинжилгээ, тэдгээрийн хүртээмж чанар, өнөөгийн нөхцөл байдлыг өөрийн орны түвшинтэй харьцуулан үзэх боломж бүрдсэн.
- Олон улсын байгууллагын экспертүүдтэй уулзаж, өөрийн орны нөхцөл байдлыг танилцуулж, цаашид хамтран ажиллах санал солилцсон.
- ISCPAN-д албан ёсны гишүүн болж, байнгын харилцаа холбоотой ажиллах боломж бүрдсэн.

Шинэлэг санаа:

- Хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн гэрч болох нь өөрөө хүчирхийллийн шинэ хэлбэр.
- Хүүхдийн хүчирхийлэл нь хүүхдийн тархины хөгжил, зан төлөв, амжилтанд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх.
- Анхан шатны урьдчилан сэргийлэлтийг сайжруулах.
- Хүүхэд хамгааллыг бие даасан салбар болгон хөгжүүлэх.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ мэргэжлийн байх.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах,
- Судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх, судлагаанд суурилсан төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх,
- Боловсон хүчнийг чадавхжуулах, олон хувилбарт үйлчилгээг чанартай хүргэх чадварыг улам сайжруулах,
- Гадны улс орны туршлага судлах боломжийг бүрдүүлэх,
- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг тогтмолжуулах
- Олон нийтийн хандлагыг өөрчлөх, тэдний оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

- Эцэг эх асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх,
- Хүүхдийн хэрэгцээнд суурилсан хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргагч нарт мэдээлэл хүргэн ажиллахаар төлөвлөж байна.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

С.БАЙГАЛМАА
С.БАТСҮХ
Н.ХӨХӨӨ